



Ховд аймгийн “Хан Алтайн бvргэдvнд” клубын уулчид 6 сарын 7-ны одор Алтайн уулсын ноёлыг оргилуудын нэг, дархан цаазат “Хөх сэрэг”-ийн нурууны ноён оргил 4129 метр ондор “Тахилт” оргилд авиран гарчээ.

Энэхvв авиралтыг Онцгой байдлын алба vвсэн байгуулагдсаны ойн хvрээнд Ховд аймаг дахь тус албанаас зохион байгуулсан богоод “Хан Алтайн бvргэдvнд” клубын уулчид аймгийн ОБА-ны залуу уулчдыг дагуулан авирч, нэг ёсны ондор уулын авиралтын томоохон сургуульлалт болсон юм.



Уулчдын багийг Монгол улсын гавьяат уулчин ОУХМ Т.Гvррагчаа, Спортын мастер, нэрт дасгалжуулагч багш Б.Эрхэмбаяр нар ахалж, Спортын мастер

Д.Монх-Эрдэнэ, спортын дэд мастер Х.Бямбасүрэн, дэд мастер Г.Тормонх, дэд мастер Д.Бохжаргал нарын шигшээ тамирчид, мон залуу уулчин Ховд их сургуулийн биеийн тамирын ангийн оюутан Болорцэцэг, Батхишиг, Онцгой байдлын хэлтсийн орлогч дарга хошууч Олзийхишиг, ахлах дэслэгч Лхагва-Очир, ахлах ахлагч Монхзул, Доржбат, Тэмүжин, 12 жилийн 1-р сургуулийн сурагч залуу уулчин Д.Дэлгэрцэцэг мон уулчин Лхагвадорж нарын бүрэлдэхвүнтэй авирсан байна. Энэ удаагийн авиралтанд аймгийн Засаг дарга оролцсон нь бас нэг онцлох зүйл ажээ.



Түүнчилэн энэ авиралт нь 6 сарын 10-14-нд Говь-Алтай аймгийн Тонхил суманд болон Сутай хайрханд болох Монголын уулчдын 2014 оны нэгдсэн авиралт, улсын аврага шалгаруулах тэмцээний өмнөхөн явагдсанаараа онцлогтой. Оороор хэлбэл Онцгой байдлын албанаас аймгийнхаа уулчдыг болон уулын спортын хөгжлийг дэмжсэн сайхан үйл явдал боллоо хэмээн уулчид үгүүлж байна.

“Хан Алтайн бүргэдүүд” клубын уулчид “Хөх Сэрэг”-ийн авиралтаас ирмэгцээ, ондор уулын спортын улсын аварга шалгаруулах тэмцээн болон 2014 оны Монголын уулчдын нэгдсэн авиралтанд оролцохоор 6 сарын 9-ны өдөр Говь-Алтай аймгийг зорьж байгаа юм.

Г.Энх